



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

14201 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 1,
Утас/Факс: (976-11) 32-06-68

2020.02.20 № 3/455
танай _____ -ны № _____ -т

МОБИКОМ КОРПОРАЦИ,
СКАЙТЕЛ КОМПАНИ,
ЮНИТЕЛ ГРУПП ХХК,
"ЖИМОБАЙЛ" ХХК-ИУДАД

Уриалга хүргүүлэх тухай

Дэлхийн нийтийг түгшээсэн шинэ төрлийн коронавирусын дэгдэлтийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүрээнд орон даяар хорио цээр тогтоож бүх төрлийн боловсролын байгууллагын танхимын сургалтыг зогсоож зайн хэлбэрт шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Засгийн Газрын 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн хуралдааны шийдвэрээр хорио цээр болон боловсролын байгууллагуудын танхимын сургалт эхлэх хугацааг 03 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл сунгалаа.

Улс даяар өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан их, дээд сургуулиуд сургалтын цахим хэлбэрт шилжин олон мянган багш, эрдэмтэд лекц, семинарын материалыг цахим болгон суралцагчдад илгээх, даалгавраа эргүүлэн авах зарчмаар ажиллаж байна.


Хот болон орон нутагт дахь суралцагчдын интернетийн бололцооноос хамааран ихэвчлэн гар утаснаас цахим сургалтад оролцож байгаа нь санхүүгийн хүндрэл учруулж, хичээлдээ хамрагдах боломжийг хязгаарлах нөхцөл болоод байна.

Иймд Монгол Улсын Их Сургуулиас хорио цээрийг сунгасан энэ үед суралцагчдад сурах боломжийг олгохын тулд их сургуулиудын удирдлагын систем (МУИС-ийн хувьд <http://sisi.num.edu.mn>) болон хичээлийн видео байршуулсан <http://youtube.com> серверт 03 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хандахад үүрэн холбооны дата хэрэглээг үнэ төлбөргүй болгох уриалгыг дэвшүүлж байна.

Танай байгууллага улс орны өмнө тулгарсан онцгой нөхцөл байдлыг хамтдаа туулах нийгмийн хариуцлагынхаа хүрээнд манай байгууллагаас гаргасан уриалгыг дэмжиж бидэнтэй хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ХАМТЫН АЖИЛЛАГАА
ХАРИУЦСАН ДЭД ЗАХИРАЛ

Ч.ЛОДОЙРАВСАЛ



В: 2020 ALBAN BICHIG P- 83

3340000453